

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сэлэнгэ аймгийн Хушаат сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2025/112/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn

Сүхбаатар сум
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: "Бэйкер Тилли Далайван аудит" ХХК

Утас: 99396969 Цахим хаяг: urtaa6969@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1. Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2. Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.5.1 Төсвийн төлөвлөлт	14
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	14
3.5.3 Нэмэлт төсөв:	15
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	15
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.1 Төлбөрийн акт	18
5.2 Албан шаардлага	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БЕГ	Боловсролын ерөнхи газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ХУШААТ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Э.АРИУНАА ТАНАА

2025. 02. 25 № СЭА-2025/112-НА-СТА
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Хушаат сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд аймгийн БЕГ-аас 7,960.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер, 44,147.5 мянган төгрөгийн ном, Chrombook, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 20,000.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил үнэ төлбөргүйгээр хүлээн авсан, Мексим Консалтинг ХХК-тай байгуулсан гэрээний дагуу 79,684.7 мянган төгрөгийн цахим ангийн тоног төхөөрөмжийг зээлийн нөхцөлөөр авсан байна.

Аудитын гол асуудал

Дээд шатны төсвийн захирагчаас тус сургуулийн тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 9 удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус "бараа үйлчилгээний бусад зардал" гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2 зорилтын хүрээнд 76 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 96.4 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

			<i>/Төгрөгөөр/</i>
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	136,086,009.17	196,474,610.76
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	109,310,624.23	156,194,415.42
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	109,310,624.23	156,194,415.42
31210	Төгрөг	109,310,624.23	156,194,415.42
31211	Төрийн сангийн харилцах	109,310,624.23	156,194,415.42
35	БАРАА МАТЕРИАЛ	26,775,384.94	40,280,195.34
351	Түүхий эд материал	2,793,304.94	7,314,678.34
3511	Тусгай зориулалттай материал	2,793,304.94	7,314,678.34
353	Бэлэн бүтээгдэхүүн	0.00	971.00
35400	Хангамжийн материал	23,982,080.00	32,964,546.00
35410	Бичиг хэргийн материал	408,600.00	0.00
3543	Сэлбэг хэрэгсэл	949,900.00	949,900.00
35460	Хүнсний материал	0.00	3,466.00
35470	Бусад хангамжийн материал	22,623,580.00	32,011,180.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,353,836,841.74	1,450,293,926.87
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,353,836,841.74	1,450,293,926.87
39200	Биет хөрөнгө	1,323,736,841.74	1,420,193,926.87
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,315,727,094.28	1,315,727,094.28
39202	Хуримтлагдсан элэгдэл	(175,871,529.36)	(226,506,697.92)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	14,562,500.00	14,562,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(14,562,500.00)	(14,562,500.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	160,518,215.40	315,496,546.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(36,710,532.74)	(58,695,442.07)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	61,523,755.93	89,006,755.93
39208	Хуримтлагдсан элэгдэл	(26,077,590.85)	(37,141,144.71)
39214	Бусад үндсэн хөрөнгө	15,972,100.00	15,972,100.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,920,612.22)	(7,973,451.94)
39217	Ном	13,575,941.30	14,308,166.90
39300	Биет бус хөрөнгө	30,100,000.00	30,100,000.00
39301	Програм хангамж	225,000.00	225,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(225,000.00)	(225,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	30,100,000.00	30,100,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,489,922,850.91	1,646,768,537.63
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	34,507,760.00	80,559,221.43
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	34,507,760.00	80,559,221.43
413	Өглөг	34,507,760.00	80,559,221.43
4131	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	172,930.66
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг	34,507,760.00	701,602.77
4136	Бусад өглөг	0.00	79,684,688.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	79,684,688.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,455,415,090.91	1,566,209,316.20

51	Засгийн газрын хувь оролцоо	1,455,415,090.91	1,566,209,316.20
51100	Засгийн газрын оруулсан капитал	252,501,089.66	252,501,089.66
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	252,501,089.66	252,501,089.66
51200	Хуримтлагдсан үр дүн	512,674,056.18	623,468,281.47
51210	Өмнөх үеийн үр дүн	512,674,056.18	512,674,056.18
51220	Тайлант үеийн үр дүн		110,794,225.29
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	690,239,945.07	690,239,945.07
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,489,922,850.91	1,646,768,537.63

2.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

<i>/төгрөгөөр/</i>			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,126,407,241.88	1,704,649,144.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	71,974,197.04	86,838,944.00
120	Нийтлэг татварын бус орлого	71,974,197.04	86,838,944.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,741,418.00	10,210,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,574,400.00	10,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,167,018.00	210,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	54,193,294.10	72,107,570.60
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	14,039,484.94	4,521,373.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,054,433,044.84	1,617,810,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	918,051,100.00	1,396,265,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	918,051,100.00	1,396,265,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	10,400,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	10,400,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	136,381,944.84	211,144,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	136,381,944.84	211,144,700.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,103,844,169.22	1,593,222,410.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,103,844,169.22	1,593,222,410.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,071,977,619.22	1,560,727,910.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	671,437,587.20	1,049,507,617.46
210101	Үндсэн цалин	478,475,755.13	646,057,398.81
210102	Нэмэгдэл	169,945,352.91	370,360,353.65
210104	Урамшуулал	23,016,479.16	33,089,865.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	84,602,109.71	129,859,588.54
210201	Тэтгэврийн даатгал	58,407,427.78	87,886,747.42
210202	Тэтгэмжийн даатгал	6,713,632.60	11,152,683.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,359,574.61	5,351,089.73
210204	Ажилгүйдлийн даатгал	1,283,862.14	5,160,444.19

210205	Эрүүл мэндийн даатгал	12,837,612.58	20,308,623.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	162,997,104.84	164,338,542.77
210301	Гэрэл, цахилгаан	9,615,544.84	9,685,802.77
210302	Түлш, халаалт	149,610,060.00	149,652,740.00
210303	Цэвэр, бохир ус	3,771,500.00	5,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	0.00
2105	Нормативт зардал	31,480,983.07	36,794,000.00
210502	Хоол, хүнс	31,480,983.07	36,794,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,892,600.00	22,360,000.00
210604	Урсгал засвар	7,892,600.00	22,360,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,451,180.00	16,726,054.47
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,324,400.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,126,780.00	16,726,054.47
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	107,116,054.40	141,142,107.25
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,670,175.20	44,170,530.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,072,900.00	9,767,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	75,372,979.20	87,203,977.25
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,866,550.00	32,494,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,866,550.00	32,494,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	31,866,550.00	32,494,500.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	22,563,072.66	111,426,733.51
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	632,508.22
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.00	632,508.22
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	22,563,072.66	110,794,225.29

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

			<i>/төгрөгөөр/</i>	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН	
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,058,174,462.84	1,628,020,200.00	
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,741,418.00	10,210,000.00	
120	Нийтлэг татварын бус орлого	3,741,418.00	10,210,000.00	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,741,418.00	10,210,000.00	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,574,400.00	10,000,000.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,167,018.00	210,000.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,054,433,044.84	1,617,810,200.00	
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	918,051,100.00	1,396,265,500.00	
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	918,051,100.00	1,396,265,500.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	10,400,000.00	

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	10,400,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	136,381,944.84	211,144,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	136,381,944.84	211,144,700.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	996,437,626.75	1,548,635,096.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	996,437,626.75	1,548,635,096.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	964,572,576.75	1,516,139,625.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	671,437,587.20	1,049,334,686.80
210101	Үндсэн цалин	478,475,755.13	645,884,468.15
210102	Нэмэгдэл	169,945,352.91	370,360,353.65
210104	Урамшуулал	23,016,479.16	33,089,865.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	84,602,109.71	129,859,588.54
210201	Тэтгэврийн даатгал	58,407,427.78	87,886,747.42
210202	Тэтгэмжийн даатгал	6,713,632.60	11,152,683.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,359,574.61	5,351,089.73
210204	Ажилгүйдлийн даатгал	1,283,862.14	5,160,444.19
210205	Эрүүл мэндийн даатгал	12,837,612.58	20,308,623.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	128,489,344.84	198,144,700.00
210301	Гэрэл, цахилгаан	9,615,544.84	8,984,200.00
210302	Түлш, халаалт	115,102,300.00	184,160,500.00
210303	Цэвэр, бохир ус	3,771,500.00	5,000,000.00
2105	Нормативт зардал	31,475,485.00	36,797,466.00
210502	Хоол, хүнс	31,475,485.00	36,797,466.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,892,600.00	22,360,000.00
210604	Урсгал засвар	7,892,600.00	22,360,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,921,180.00	16,726,054.47
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,324,400.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,596,780.00	16,726,054.47
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,754,270.00	62,917,130.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,357,770.00	53,403,130.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,396,500.00	9,514,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,865,050.00	32,495,471.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,865,050.00	32,495,471.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	31,865,050.00	32,495,471.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	61,736,836.09	79,385,103.19
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	0.00	0.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	23,764,000.00	32,501,312.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	23,764,000.00	32,501,312.00

2200	Дотоод эх үүсвэрээр	23,764,000.00	32,501,312.00
222001	Тоног төхөөрөмж	14,684,000.00	25,018,312.00
223001	Бусад хөрөнгө	9,080,000.00	7,483,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(23,764,000.00)	(32,501,312.00)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	37,972,836.09	46,883,791.19
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		109,310,624.23
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		156,194,415.42

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	252,501,089.66	690,239,945.07	512,674,056.18	1,455,415,090.91
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	110,794,225.29	110,794,225.29
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	252,501,089.66	690,239,945.07	623,468,281.47	1,566,209,316.20

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,736,001,900.00	1,581,136,408.81	154,865,491.19	91.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,736,001,900.00	1,581,136,408.81	154,865,491.19	91.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,699,890,100.00	1,516,139,625.81	183,750,474.19	89.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,162,815,500.00	1,049,334,686.80	113,480,813.20	90.2
210101	Үндсэн цалин	743,170,200.00	645,884,468.15	97,285,731.85	86.9
210102	Нэмэгдэл	406,876,500.00	370,360,353.65	36,516,146.35	91.0
210104	Урамшуулал	12,768,800.00	33,089,865.00	(20,321,065.00)	259.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	145,352,300.00	129,859,588.54	15,492,711.46	89.3
210201	Тэтгэврийн даатгал	98,839,400.00	87,886,747.42	10,952,652.58	88.9
210202	Тэтгэмжийн даатгал	11,628,200.00	11,152,683.72	475,516.28	95.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,814,200.00	5,351,089.73	463,110.27	92.0
210204	Ажилгүйдлийн даатгал	5,814,200.00	5,160,444.19	653,755.81	88.8
210205	Эрүүл мэндийн даатгал	23,256,300.00	20,308,623.48	2,947,676.52	87.3

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	198,144,700.00	198,144,700.00	0.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	8,984,200.00	8,984,200.00	0.00	100.0
210302	Түлш, халаалт	184,160,500.00	184,160,500.00	0.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	5,000,000.00	5,000,000.00	0.00	100.0
2105	Нормативт зардал	46,008,600.00	36,797,466.00	9,211,134.00	80.0
210502	Хоол, хүнс	46,008,600.00	36,797,466.00	9,211,134.00	80.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,400,000.00	22,360,000.00	1,040,000.00	95.6
210604	Урсгал засвар	23,400,000.00	22,360,000.00	1,040,000.00	95.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,172,600.00	16,726,054.47	5,446,545.53	75.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад ажил	190,000.00	0.00	190,000.00	0.0
210806	Мэдээлэл, технологийн	21,982,600.00	16,726,054.47	5,256,545.53	76.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	101,996,400.00	62,917,130.00	39,079,270.00	61.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	92,482,400.00	53,403,130.00	39,079,270.00	57.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,514,000.00	9,514,000.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,111,800.00	32,495,471.00	3,616,329.00	90.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,111,800.00	32,495,471.00	3,616,329.00	90.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	36,111,800.00	32,495,471.00	3,616,329.00	90.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	32,501,312.00	(32,501,312.00)	
	Дотоод эх үүсвэрээр	0.00	32,501,312.00	(32,501,312.00)	
222001	Тоног төхөөрөмж	0.00	25,018,312.00	(25,018,312.00)	
223001	Бусад хөрөнгө	0.00	7,483,000.00	(7,483,000.00)	
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,737,330,824.23	1,628,020,200.00	109,310,624.23	93.7
131	Улсын төсвөөс санхүүжих	1,406,665,500.00	1,406,665,500.00	0.00	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,396,265,500.00	1,396,265,500.00	0.00	100.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,400,000.00	10,400,000.00	0.00	100.0
132	Орон нутгийн төсвөөс	211,144,700.00	211,144,700.00	0.00	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	10,210,000.00	10,210,000.00	0.00	100.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос	10,000,000.00	10,000,000.00	0.00	100.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос	210,000.00	210,000.00	0.00	100.0
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	109,310,624.23	109,310,624.23	0.00	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		156,194,415.42	0.00	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хушаат сумын ерөнхий боловсролын сургууль нь “Хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж хамтдаа хөгжиж амжилтаа ахиулцгаая” гэсэн зорилго тавин ажиллаж байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүүхэд нэг бүрийг завсардалтгүй тэгш хамруулан сургаж төлөвшүүлэн авьяасыг нээн хөгжүүлэх
- Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлийн үед бэлэн байдлыг ханган бэлэн байдлыг ханган цахим даалгаврын сан бүрдүүлж сургалтын арга хэлбэрийг сонгон заах арга зүйгээ хөгжүүлэх
- Эрүүл аюулгүй ээлтэй сургалтын орчин бүрдүүлэх
- Сурлагын хоцрогдлыг арилгах нөхөх сургалт үйл ажиллагааны чанарыг сайжруулах хүүхэд нэг бүрийн ахиц амжилт
- Эрүүл мэндийн байдал /эрүүл чийрэг байдал, эрүүл харилцаа, эрүүл аюулгүй орчин/

3.2. Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;*
- *Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 84 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт,

шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хушаат сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллага нь БШУС-ын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, шинжлэх ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хушаат сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 156,845.7 мянган төгрөгөөр буюу 10.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	109,310.6	156,194.4	46,883.8
Авлага			
Бараа материал	26,775.4	40,280.2	13,504.8
Үндсэн хөрөнгө	1,353,836.8	1,450,293.9	96,457.1
Нийт хөрөнгө	1,489,922.8	1,646,768.5	156,845.7
Өр төлбөр	34,507.8	80,559.2	46,051.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,455,415.0	1,566,209.3	110,794.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,489,922.8	1,646,768.5	156,845.7

Дээрх хүснэгтээс үзэхэд дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 156,194.4 мянган төгрөг болж 46,883.8 мянган төгрөгөөр буурсан нь мөнгөн хөрөнгийн зарцуулалттай холбоотой,
- Бараа материал дансны үлдэгдэл 40,280.2 мянган төгрөг болж 13,504.8 мянган төгрөгөөр өссөн нь БЕГ-с 4,521.3 мянган төгрөгийн ном сурах бичиг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан, төсвийн хөрөнгөөр 135,957.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 126,974.0 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 1,795,398.1 мянган төгрөг болж 183,193.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь БЕГ-с 7,960.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер, 44,147.5 мянган төгрөгийн ном, Chrombook, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 20,000.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил үнэ төлбөргүйгээр хүлээн авсан, төсвийн хөрөнгөөр 32,501.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авч, Мексим Консалтинг ХХК-тай байгуулсан гэрээний дагуу 79,684.7 мянган төгрөгийн цахим ангийн тоног төхөөрөмжийг зээлийн нөхцөлөөр авсан, сумын ИТХ-ын 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 10 дугаар тогтоолоор 1,100.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж акталж данснаас хассан, 87,204.0 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос,
- Өр төлбөр дансны үлдэгдэл 80,559.2 мянган төгрөг болж 46,051.4 мянган төгрөгөөр өссөн нь цахим дэлгүүрээс авсан 79,684.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийн үлдэгдэл төлбөр, 701.6 мянган төгрөгийн гэрэл цахилгааны, 172.9 мянган төгрөгийн ХХОАТ-ын өр төлбөр үүссэнээс тус тус шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд улсын төсвөөс 1,453,268.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 211,144.7 мянган төгрөг, нийт 1,664,412.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийн саналыг цалин хөлсийг 303,410.3 мянган төгрөгөөр буруулж 1,361,002.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд 9 удаа төсвийн зохицуулалт хийгдэж цалин, НДШ-ийн зардлыг 320,317.1 мянган төгрөгөөр, дотуур байрны хоолны зардлыг 4,413.5 мянган төгрөгөөр, үдийн цайны зардлыг 3,319.6 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 46,949.3 мянган төгрөгөөр нийт 374,999.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж улсын төсвөөс 1,405,146.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 221,544.7 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 109,310.6 мянган төгрөг буюу нийт **1,736,001.9** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 17 арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсний дагуу нийт 1,736,001.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 1,581,136.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,581,136.4 мянган төгрөг буюу 91.1 хувьтай байгаа нь үдийн цайны зардал 3,616.4 мянган төгрөгөөр, дотуур байрны зардлыг 68,857.9 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны зардлыг 82,391.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

<i>(мянган төгрөгөөр)</i>						
	Хөтөлбөр зориулалт	Үзүүлэлт	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	80226	Байр ашиглалтын үйлчилгээ	2,564.0	1,765.9	798.1	68.9
2	80233	Хүүхэд хамгаалал	2,568.8	2,538.8	30.0	98.8
3	80312	Сургалт семинар	2,029.9	2,029.9	-	100.0
4	81605	Эрүүл мэндийг дэмжих	2,397.0	2,397.0	-	100.0
5	81801	Үдийн цай	36,111.9	32,495.5	3,616.4	90.0
6	81806	Дотуур байрны үйлчилгээ	219,546.4	150,688.5	68,857.9	68.6
7	81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	46,284.5	45,132.8	1,151.7	97.5
8	81823	Боловсролын байгууллагын багш,ажилтны мэргэжил дээшлүүлэх	7,167.7	5,200.1	1,967.6	72.5
9	81827	Бичиг үсгийн боловсрол	13,586.9	11,557.0	2,029.9	85.1

10	81834	Боловсролын стандарт, сургалтын орчин	1,145,123.5	1,085,161.2	59,962.4	94.8
11	81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	10,503.5	10,141.8	361.7	96.6
12	81844	Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	210.0	-	210.0	-
13	81848	Сурах бичгийн түрээс	110.0	-	110.0	-
14	81875	Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	3,033.2	1,523.2	1,510.0	50.2
15	83602	ЗД-ын нөөц хөрөнгөөс хуваарилсан	10,400.0	9,360.0	1,040.0	90.0
16	83603	Нэмэлт-Дээд шатнаас хуваарилсан	12,819.9	10,000.0	2,819.9	78.0
17	80111	Орон нутгаас санхүүжих	221,544.7	211,144.7	10,400.0	95.3
		Нийт дүн	1,736,001.9	1,581,136.4	154,865.5	91.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны "Чиглэл хүргүүлэх тухай" албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд дараах худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХА тухай хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

/ мянган төгрөгөөр /

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Тендер шалгаруулалтын арга
1	Дотуур байрны хоол	41,595.1	41,355.6	Харьцуулалт
2	Үдийн цай	34,792.2	34,545.7	Харьцуулалт
	Нийт дүн	76,387.3	75,901.3	

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтыг 4 сард зарлан "Үдийн цай"-ны СЭАХУШСЭБС/20240201002/, "Дотуур байр"-ны СЭАХУШСЭБС/20240201004/ тендер шалгаруултанд "Хөшөө чулуу ХХК шалгарч гэрээ байгуулж, худалдан авалтыг хийж гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Хушаат сумын ерөнхий боловсролын сургуулийн /цаашид Хушаат сумын ерөнхий боловсролын сургууль гэх/ 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарын аудитор Ц.Уртнасан, анхан шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Хушаат сумын ерөнхий боловсролын сургууль нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарт 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,103,844.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 11,038.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Хушаат сумын ерөнхий боловсролын сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Хушаат сумын ерөнхий боловсролын сургууль нь мэдээлбэл зохих 20 төрлийн 171 мэдээллээс 171 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 173 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2024 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 300.0 мянган төгрөгийн цалин илүү олгосон зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 1,578.2 мянган төгрөгийн хүнсний материалын худалдан авалт, зарцуулалтыг тухай бүр бүртгэж байх, шилэн дансны мэдээллийг тогтоосон хугацаанд нь бүрэн мэдээлж байх 2 зөвлөмж өгсөн байна.

Албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт тогтоох	1	300.0	1	300.0	100.0
Зөвлөмж	2	1,578.2	1	1,578.2	100.0
Нийт дүн	3	1,878.2	2	1,878.2	100.0

4.6 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт **162,033.1** мянган төгрөгийн дараах алдааг залрууллаа. Үүнд:

- Санхүүгийн тайланд 77,977.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө орлогод аваагүй, 79,121.3 мянган төгрөгийн өглөг тусгаагүй, 3,622.3 мянган төгрөгийн бараа материал илүү тусгасан,
- Цалингийн зардлыг 1,311.7 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4. Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.1-д “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.5-д “бүх орлого” 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Аудитаар нийт **4,325.3** мянган төгрөгийн зөрчил илэрснээс 3,450.8 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 874.5 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүллээ.

5.1 ТӨЛБӨРИЙН АКТ

1.Сэлэнгэ аймгийн Боловсролын газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн Б/10 дугаар тушаалаар сургуулийн захирал Э.Ариунаад сахилгын шийтгэл ногдуулсан боловч ур чадварын нэмэгдэлд 2,985.0 мянган төгрөгийг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, БШУС,ХНХ, СС-ын сайдын 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/35, А/10, 9 дугаар хамтарсан тушаалын 3 дахь “Багш ажилтанд ур чадварын нэмэгдэл олгоход дараах нийтлэг шалгуурыг харгалзана” 3.2-д “Ёс зүйн зөрчилгүй, сахилгын шийтгэлгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ур чадварын нэмэгдлийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2.Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авсан багш Ц.Долгорсүрэнгийн ажилласан хоногийг зөрүүтэй тооцож, 465.8 мянган төгрөгийн цалин илүү

олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.2 АЛБАН ШААРДЛАГА

1.Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 701.6 мянган төгрөгийн гэрэл цахилгааны, 172.9 мянган төгрөгийн ХХОАТ-ын зэрэг нийт 874.5 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Хөрөнгө орлогод аваагүй	1	77,977.8	1	77,977.8			1	77,977.8				
Санхүүгийн тайланд өглөг тусгаагүй	1	79,121.3	1	79,121.3			1	79,121.3				
Бараа материал илүү тусгасан	1	3,622.3			1	3,622.3	1	3,622.3				
Цалингийн зардал илүү тайлгансан	1	1,311.7			1	1,311.7	1	1,311.7				
Дүн	4	162,033.1	2	157,099.1	2	4,934.0	4	162,033.1				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалин илүү олгосон	2	3,450.8	2	3,450.8								
Өр төлбөр үүсгэсэн	1	874.5			1	874.5						
Дүн	3	4,325.3	2	3,450.8	1	874.5						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил											
											-
Дүн											-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил											
											-
Дүн											-
Нийт дүн											-